



УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
б дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201

Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08.

Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

дт 23. 03. 31 № ХН/740  
таний —ны № -т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хийх Монгол Улсыг гадаадад сурталчлах бодлого, стратеги, хамтын ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээний талаарх Ерөнхий сайдын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ...хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

## **МОНГОЛ УЛСЫГ ГАДААДАД СУРТАЛЧЛАХ БОДЛОГО, СТРАТЕГИ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ЭРЧИМЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙХ МЭДЭЭЛЭЛ**

Монгол Улсын Засгийн газраас Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлого болон "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" зэрэг баримт бичигт тусгасны дагуу Монгол үндэстний оршин тогтох амин чухал дархлаа болох Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалах, хөгжүүлэх, дэлхийн улс орнуудтай соёлын хамтын ажиллагааг өргөжүүлж, дипломат төлөөлөл болон иргэдээрээ дамжуулан дэлхий дахинд сурталчлах, улс орныхоо гадаад нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэх ажлыг эрчимжүүлэхэд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Олон улсын харилцаанд "зөөлөн хүч" (soft power), "ухаалаг хүч" (smart power)-ний талаарх ойлголт улам өргөн хэрэглэгдэж байна. Зөөлөн хүч нь хэл, соёл, урлаг, боловсрол, улс төрийн үзэл суртал, үнэт зүйл, гадаад бодлогын манлайллаар бусдыг татах, нелөөлвөө тогтоох, улмаар зорилгодоо хүрэх гадагш чиглэсэн бодлого байдаг бөгөөд Монгол Улсын түүх, соёлын уламжлал, эдийн засаг, нийгмийн салбарын ололтыг олон улсад сурталчлан таниулах зорилгоор "Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр"<sup>1</sup>, "Дэлхийн Монголчууд" хөтөлбөрийг 2016-2020 онд амжилттай хэрэгжүүлсэн.

Эдгээр хөтөлбөрүүдийн үр дүнд бий болсон үндэс суурийг улам бэхжүүлж, үргэлжлүүлэх, төгөлдөржүүлэх зорилтын хүрээнд 2021-2024 онд хэрэгжүүлэх ажлуудыг төлөвлөн "Монгол Үндэстний үнэлэмж", "Дэлхийн Монголчууд-II" цогц арга хэмжээг батлан хэрэгжүүлж байна.

### **"Монгол Үндэстний үнэлэмж" цогц арга хэмжээний хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газраас 2016-2020 онд хэрэгжүүлсэн "Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр"-ийн үр дүнд гадаад сурталчилгааны бодлого, үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагууд, олон нийт хамтран үр дүнтэй хэрэгжүүлэх, харилцан уялдаа холбоотой ажиллах нөхцөл боломж бүрдсэн. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний зөвлөлийг Гадаад харилцааны сайдаар ахлуулан гадаад сурталчилгааны үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангаж, хамтрагч байгууллага бүр өөрийн тесев, нөөц бололцооны хүрээнд үр дүнтэй зохион байгуулсан.

"Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т дэлхийн улс орнуудтай соёлын харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлэх замаар гадаад сурталчилгааг эрчимжүүлэх, гадаад таатай орчныг бүрдүүлэх, монгол хэл, соёл, монгол судлалыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулахад чиглэсэн "Монгол Үндэстний үнэлэмж" цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий Зөвлөлийг

<sup>1</sup> "Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр"-ийг Засгийн газрын 2016 оны 2 дугаар тогтоолоор батлан, 2016-2020 онд хэрэгжүүлсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд дэлхийн 40 гаруй улсад 740 гаруй ажил, арга хэмжээг зохион байгуулсан байна. Тухайлбал, соёл, урлагийн чиглэлээр 309, хэвлэл мэдээллийн чиглэлээр 100, Монгол судлалын чиглэлээр 69, аялал жуулчлалын чиглэлээр 122, үндэсний брэнд, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах ажлын хүрээнд 84, спортын чиглэлээр 61 ажил, арга хэмжээг зохион байгуулав.

Гадаад харилцааны сайдаар ахлуулан 13 яам, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийн бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна.

Энэхүү цогц арга хэмжээний хүрээнд б зорилтыг дэвшүүлээд байна. Үүнд:

- Монгол үндэстний үнэт зүйлс, түүх, биет болон биет бус соёлын өв, уламжлалт болон орчин үеийн соёл, урлаг, оюуны болон дижитал бүтээл, спортын амжилтыг дэлхийн хэмжээнд сурталчлах;
- Монгол судлалын хүрээг тэлж, дэлхийд тархсан монгол өв, дурсгалыг хамгаалах;
- Хилийн чанадад Монголын соёл, мэдээллийн төв байгуулж, үйл ажиллагааг нь дэмжих;
- Монгол Улсын хөгжлийн ололт амжилт, мега төсөл, хөтөлбөрийг хилийн чанадад танилцуулж, хөрөнгө оруулагч, хамтран хэрэгжүүлэгч олоход дэмжлэг үзүүлэх;
- Худалдаа, эдийн засгийн гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх;
- Аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр 16 багц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Цогц арга хэмжээг хэрэгжүүлж, гадаад сурталчилгааг эрчимжүүлэхэд зориулан тодорхой санхүүжилтийг төсөвт тусгасан бөгөөд 2022-2023 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- "Монголын нууц товчоо"-г гадаад хэлээр орчуулан цогц боть болгон хэвлүүлэх төслийг эхлүүлж, 2022 онд болгар хэл дээр 4 дэх хэвлэлт, румын, грек, вьетнам хэл дээр анх удаа хөрвүүлэн хэвлүүлэв. Ингэснээр тус бүтээл дэлхийн 33 орны хэл дээр хэвлэгдээд байна.
- Бүгд Найрамдах Чех Улсын Карлын их сургуулийн Монгол судлалын тэнхимээс англи хэл дээр эрхлэн гаргадаг "Mongolica Pragensia" сэтгүүлийн хоёр дугаарыг санхүүжүүлж хэвлүүлснээр 2 жил тасалдаад байсан уг сэтгүүл судалгааны эргэлтэд оров.
- АНУ-ын Конгрессын номын сангийн гар бичмэлийн тасагт хадгалагдаж байгаа баримтаас эмхэтгэн "Дилова хутагтын захидал бичиг" номыг хэвлүүлэв.
- ЮНЕСКО-ийн Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенц батлагдсаны 50 жилийн оид зориулсан Дэлхийн өвийн сэтгүүлийн 2022 оны 11 дүгээр сарын тусгай дугаарт Монгол Улсаас Дэлхийн өвд бүртгэгдсэн өвийн газрууд, Монгол Улсын өвийн чиглэлээр баримталж буй бодлого, стратеги, хамгаалалтын менежментийн талаар нийтлэл, ХБНГУ-ын Берлин хотын "Миний дүүрэг", Нидерландын Хаант Улсын "Дипломатик Уорлд", Бүгд Найрамдах Франц Улсын аялал жуулчлалын "Petit Fute" сэтгүүлд (тус бүр 10 гаруй хуудас) Монгол Улсын талаар томоохон нийтлэл, мэдээлэл хэвлүүлэв.
- Дэлхийн өвийн сэтгүүлийн "Google Arts and Culture Platform"-д ЮНЕСКО-д бүртгэгдсэн Монголын 5 өвийн газрын танилцуулгыг байршуулах гэрээ байгуулав.
- БНХАУ-ын Бээжин хотноо "Монголын соёл, мэдээллийн төв"-ийг 2022 онд нээн үйл ажиллагааг нь эхлүүлээд байна.
- Монголын байгалийн гэрэл зургийн "Amazing Mongolia" альбом гаргаж, хөдөлгөөнт үзэсгэлэн бүтээн БНСУ-ын Сөүл хотноо толилуулав. Мөн Чойжин ламын сүм музейтэй хамтарсан "Хот мандал" хөдөлгөөнт үзэсгэлэнг бүтээж 20 гаруй оронд толилуулаад байна.

*Соёл урлаг, аялал жуулчлалын чиглэлээр:*

Соёл, урлаг, оюуны бүтээлийн олон улсын өндөр зэрэглэлийн наадам, үзэсгэлэнд тогтмол оролцож, эх орноо гадаадад өргөн хүрээнд сурталчлах тухай Засгийн газрын шийдвэрийн дагуу 2022 онд Монгол Улс анх удаа Италийн Венецийн олон улсын урлагийн биенналье, Францын Каннын олон улсын кино наадамд албан ёсоор өөрийн танхимтай оролцов.

2022 онд Монгол Улс, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Морин хуурын чуулпын бүрэн хэмжээний тоглолтыг Японы NHK телевизийн концертын төв танхимд, Монгол Улс, Франц Улсын парламент хоорондын харилцааны 30 жилийн ой, Монгол Улс ЮНЕСКО-д элссэний 60 жилийн ойг тохиолдуулан Францын З хотод "Монголын соёлын өдрүүд" цогц арга хэмжээг зохион байгуулсны зэрэгцээ Үндэсний урлагийн их театрын "Нүүдэлчдийн домог" тоглолтыг ЮНЕСКО-ийн Төв байранд толилуулав. Уг тоглолтыг мөн Бельгийн Хаант Улсад, "Монголын киноны өдрүүд" кино наадмыг ИБУИНХУ-д, "Монгол наадам"-ыг Япон Улсад, "Соёлын үдэш"-ийг Шведийн Хаант Улсын нийслэл Стокholm хотод, ХБНГУ-д "Монголын морин хуурын анхны наадам" зэрэг нийт 130 гаруй арга хэмжээг зохион байгуулсан.

Мөн Монгол үндэсний дээл хувцсыг сурталчлан таниулах зорилгоор хилийн чанад дахь 49 дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан "Монгол хувцасны нууц товчоон" баримттай киног суугаа болон хавсрсан суугаа орондоо сурталчлах ажлыг өргөн хүрээнд зохион байгууллаа.

Харин энэ онд Монголын үндэсний болон орчин үеийн урлагийг танилцуулан сурталчлах тоглолтыг АНУ-д аялан тоглуулахаар төлөвлөж байна. Мөн Бүгд Найрамдах Франц Улсын Нант хотын түүхийн музейд "Чингис хаан-Монголчууд дэлхийг хэрхэн өөрчилсөн бэ" сэдэвт үзэсгэлэнг зохион байгуулах бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоолоор Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороог байгуулж, улмаар 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан 2023 онд Монгол Улсад зохион байгуулах олон улсын чанартай арга хэмжээний хуанлийг гаргаж, хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газрууд, Монголд ажиллаж буй гадаадын хэвлэл мэдээллийн 14 байгууллагын төлөөлөгчийн газрууд, МОНЦАМЭ агентлагаар дамжуулан 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр олон улсад зарласан.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны 2023 оны анхдугаар хуралдаанаас гаргасан зөвлөмжийн дагуу "WELCOME TO MONGOLIA" сурталчилгааны материалын 49 дипломат төлөөлөгчийн газарт хуваарилан хүргүүлж байна. Мөн 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан Монгол Улсад жуулчлах зорилгоор 30 хүртэл хоногоор ирэх гадаадын 34 улсын иргэдийг 2023-2025 оныг дуустал 3 жилийн хугацаанд визийн шаардлагаас чөлөөлөх шийдвэр гаргалаа. Мөн дэлхийн 98 улсын иргэдэд 30 хүртэлх хоногийн визийг цахимаар олгож эхлээд байна.

Монгол Улсыг сурталчлан танилцуулах зорилгоор 2022 онд Бүгд Найрамдах Болгар Улсын Софи хотноо болсон олон улсын аялал жуулчлалын "Holiday & Spa International Fair" үзэсгэлэнд, "Монголд зочлох жил"-ийн хүрээнд 2023 онд ХБНГУ-ын Штутгарт хотноо "CMT Stuttgart", Хамбург хотноо "Райзен Караванинг", Бүгд

Найрамдах Унгар Улсын Будапешт хотноо "Олон улсын аялал жуулчлалын 45 дахь удаагийн үзэсгэлэн"-д тус тус амжилттай оролцсон.

### "Дэлхийн Монголчууд-II" цогц арга хэмжээний хүрээнд:

"Дэлхийн Монголчууд" хетелбэрийг 2016-2020 онд амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд уг хетелбэрийн үргэлжлэл "Дэлхийн Монголчууд-II" цогц арга хэмжээг баталж, удирдан зохион байгуулах Зөвлөлийг байгуулан 2021-2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.

Энэхүү цогц арга хэмжээ нь дараах зорилтуудыг хангана. Үүнд:

- Хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах;
- Монгол судлалын үйл ажиллагааг идэвхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийн хүүхдүүдэд чиглэсэн цахим сургалтын хетэлбер хэрэгжүүлж, тэдний эх хэлээ суралцах боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Хилийн чанад дахь Монгол Улсын иргэд, монголчуудын холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, соёл, урлаг, спорт, эрдэм шинжилгээний арга хэмжээг хамтран зохион байгуулах;
- Хилийн чанад дахь Монголын соёлын өвийг хадгалан хамгаалах, уламжлалт соёлоо дэлхий нийтэд сурталчлан таниулах зэрэг болно.

Цогц арга хэмжээний хүрээнд 2022-2023 онд дараах ажлуудыг гүйцэтгэв.

Хилийн чанадад үйл ажиллагаа явуулж байгаа монгол сургууль, цэцэрлэг, хэл соёлын төв, монгол иргэдийн санаачилгаар байгуулагдсан Монголчуудын холбоо, төрийн бус байгууллага, гадаадад нарийн мэргэжлээр сурч буй иргэдийн судалгааг 2022, 2023 онд тус тус хийсэн бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад эрс нэмэгдсэн үр дүн гарсан. Тухайлбал, хилийн чанадад үйл ажиллагаа явуулж байгаа монгол сургууль, цэцэрлэг, хэл соёлын төв 31 хувиар, Монголчуудын холбоо, төрийн бус байгууллага 30 хувиар, нарийн мэргэжлээр сурч буй иргэдийн тоо 25.2 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг 2022 оны 3 дугаар сард хилийн чанадад үйл ажиллагаа явуулж байгаа монгол сургуулийн удирдлага, багш нартай цахим уулзалт хийсний мөрөөр тэдэнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, салбар дундын уялдааг хангах чиглэлээр тодорхой ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Энэ хүрээнд хилийн чанадад үйл ажиллагаа явуулж байгаа багш нарт тавигдах мэргэжлийн стандарттай болох, багшлах эрхийг баталгаажуулсан баримт бичиг, хууль эрх зүйн орчныг тодорхой болгох, гадаад улс оронд монгол хэл сурх орчныг бүрдүүлж, сурагчдыг идэвхжүүлэх, хүүхдүүдэд зориулсан хүүхдийн нэвтрүүлэг, контент, хөтөлбөрүүдийг бэлтгэх, түгээх зэрэг ажлуудыг төлөвлөж, холбогдох байгууллагуудтай хамтран шат дараатай хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран хилийн чанад дахь монгол сургууль, хэл соёлын төвүүдийн багшийн мэргэжил, заах арга зүйг дээшлүүлэх, сургалтын чанарыг сайжруулах зорилгоор мэргэжлийн заах арга зүйн 20 цуврал цахим сургалтыг нэг жилийн хугацаанд тасралтгүй зохион байгуулж, 100 гаруй багшийг хамруулав. Сургалтад хамрагдсан багш нарыг боловсролын нэгдсэн системд бүртгэж, сертификат олгохоор ажиллаж байна.

Мөн гадаадын улс оронд суугаа монголчууд, олон улсын хэмжээнд монгол хэл, бичиг үсгийн хэрэглээ, судалгааг өргөжүүлэх, дэмжих зорилгоор 2022 онд Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийг<sup>2</sup> дипломат төлөөлөгчийн газруудыг тушиглэн Европ, Ази тивд байгуулсан бөгөөд 2023 онд АНУ-д салбар зөвлөл байгуулахаар ажиллаж байна.

Хилийн чанад дахь монгол сургууль, хэл соёлын төвүүдэд цахим сургалтын материалууд, Монгол хэлний сурх бичиг, заах арга зүйн эмхэтгэлүүд, "Үндэсний бичиг эхлэн хялбар хурдан сурх дэвтэр" болон "Монгол бичиг" нэртэй аппликеийшний<sup>3</sup> боловсруулж Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудаар дамжуулан түгээгээд байна.

Өнгөрсөн жилүүдэд дэлхий нийтээрээ цар тахлын хүнд бэрхшээлтэй нүүр тулж байсан ч хилийн чанад дахь монгол сургууль, цэцэрлэг, хэл соёлын төвүүд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн улс орныхоо нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулж ирснийг үнэлэн Гадаад харилцааны яам, Боловсрол, шинжлэх ухааны яамны хамтын ажиллагааны хүрээнд З сургуулийг шагнан урамшууллаа.

Цаашид Монгол Улсын Засгийн газраас Монгол хэлний тухай хууль, "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлого, "Дэлхийн Монголчууд-II" цогц арга хэмжээний хүрээнд хилийн чанадад оршин сууж байгаа монгол хуухдууд болон олон соёлт иргэн үндэсний соёл, заншил, эх хэл, бичгээ сурх зорилтыг хэрэгжүүлж, гадаадад үйл ажиллагаа явуулж буй монгол сургууль, цэцэрлэг, хэл соёлын төвүүдийн үйл ажиллагаанд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлж ажиллана.

"Дэлхийн Монголчууд-II" гадаад сурталчилгааны цогц арга хэмжээнд "хилийн чанад дахь Монгол Улсын иргэд, монголчуудын холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, соёл, урлаг, спорт, эрдэм шинжилгээний арга хэмжээг хамтран зохион байгуулна" гэж заасны дагуу Засгийн газрын 2021 оны 268 дугаар тогтоолын хүрээнд "Монголын бүх ард түмний XV наадам", "Монгол Үндэсний спортын VII наадам"-ын бүсийн тэмцээнийг Монгол Улсаас АНУ, БНФУ, БНСУ-д суугаа Элчин сайдын яамдтай хамтран зохион байгуулав.

ЮНЕСКО-ийн соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн "Монгол үндэсний баяр наадам"-ыг олон улсад сурталчлах, хилийн чанад дахь монгол иргэдийг дэмжих, түүх соёл, өв уламжлалаа хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилго бүхий "Миний Монгол наадам-2022" уралдааныг дэлхийн 11 улсын 15 хотод Монгол иргэд болон Монголчуудын холбоодтой хамтран амжилттай зохион байгуулсан.

Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор "Хилийн чанад дахь Монголчуудын нэгдсэн чуулга уулзалт"-ыг 2022 оны 7 дугаар сарын 3-5-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулав.

<sup>2</sup> Гадаад дахь Хэлний бодлогын салбар зөвлөлийн Европ дахь салбар зөвлөлийг ХБНГУ-д суугаа Элчин сайдын яамны, Ази дахь салбар зөвлөлийг БНСУ-д суугаа Элчин сайдын яамны дэргэд тус тус байгуулсан. Энэ онд Америк тив дэх салбар зөвлөлийг байгуулахаар ажиллаж байна.

<sup>3</sup> Цахим сургалтын З материал бэлтгэн, Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Шинжлэх ухааны академийн Хэл, зохиолын хүрээндээ хамтран "Хуухдийн эх хэлний боловсролд" эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Мал аж ахуйн соёл, Би Монгол хүн, Монгол ярианы сурх бичиг, Монгол хэлний дүймин заах арга зүйн эмхэтгэл зэрэг 350 гаруй ном, "Үндэсний бичиг эхлэн хялбар хурдан сурх дэвтэр" болон "Монгол бичиг" нэртэй аппликеийшнийг хүргүүлээд байна.

## *Монгол судлалын чиглэлээр:*

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал болон "Алсын хараа-2050" урт хугацааны бодлогын баримт бичигт Монгол судлалын чиглэлээр хэрэгжүүлэх бодлогын үндсийг тодорхойлсноос гадна дээрх 2 цогц арга хэмжээнд Монгол судлалыг хөгжүүлэх, Монгол судлалын хүрээг тэлж, дэлхийд тархсан монгол өв, дурсгалыг хамгаалах зорилтуудыг дэвшүүлсэн.

Олон улсад Монгол судлал өргөжин хөгжихийг дэмжиж, гадаадад Монгол судлалын төв байгуулах, Монгол Улсад дэлхийн Монгол судлалын төв байгуулах хүрээнд хөтөлбөр, арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлж ирсэн багаад Монгол судлалын чиглэлээр ойрын болон дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг шинэчлэн боловсруулж, батлуулахаар ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар дэлхийн 20 оронд Монгол судлалын 22 төв, 600 гаруй судлаач ажиллаж байгаагаас 200 орчим нь залуу судлаач байна.

Монгол судлалыг хөгжүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж байна. Үүнд:

- Гадаадын их, дээд сургуулийн дэргэдэх Монгол судлалын төв, тэнхимийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг идэвхжүүлэх хүрээнд АНУ-ын Харвардын их сургууль (70 сая төгрөг), Индианагийн их сургуулийн Монгол судлалын тэнхим (7000 ам.доллар), Бүгд Найрамдах Чех Улсын Карлын их сургууль (2000 ам.доллар)-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэв. Мөн БНСУ, БНФУ, ИБУИНХУ, БНИталиУ, БНЧехУ, БНПольшу, Унгар, Япон Улс дахь Монгол судлалын төвүүдийг дэмжих хүрээнд 150 ном, бүтээл хүргүүллээ. Бүгд Найрамдах Эстони Улсын Тартугийн их сургуулийн Соёл судлалын хүрээлэнгийн Дорно дахин судлалын төвийн дэргэд Монгол судлалын тусгай тасгийг 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдөр нээв.
- Залуу монгол судлаачдыг олон улсад дэмжих, залуу халааг бэлтгэх зорилгоор залуу монгол судлаачдын зуны сургуулийг Монгол судлалын үндэсний зөвлөлтэй хамтран 2022 оны 7-8 дугаар сард зохион байгуулахад гадаадын 10 улсын 17 их, дээд сургууль, судалгааны төвөөс 30 залуу судлаач, оюутан оролцов.
- Их эзэн Чингис хаан мэндэлсний 860 жилийн ойд зориулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор "Чингис хааны ертөнц ба Монгол судлал" олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Олон улсын Монгол судлалын холбоо, Монгол судлалын үндэсний зөвлөлтэй хамтран 2022 оны 8 дугаар сард зохион байгуулсан. "Монголчууд ба гадаад ертөнц" салбар хуралдааны үеэр "Чингис хаан судлалын олон улсын холбоо"-г байгуулж, Гадаад харилцааны яамнаас "Дэлхийн Монгол судлалын өдөр"-тэй болох санаачилгыг дэвшүүлэн, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-д бүртгүүлэх ажлыг эхлүүлэхээр шийдвэрлэсэн.
- 2021-2022 онд цар тахлын амаргүй нэхцэлд хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газрууд дотоод нөөц бололцоондоо тулгуурлан 20 улсад 40 гаруй хурал, семинар, лекц зохион байгуулсан байна.
- Гадаад харилцааны яам "Монгол Үндэстний үнэлээмж" цогц арга хэмжээний дэлхийд тархсан монгол өв, дурсгалыг хамгаалах зорилтын хүрээнд Чингис хаан музейн үзмэрийн сан хөмрөгийг бүрдүүлэхэд чухал дэмжлэг үзүүлсэн. Тухайлбал, гадаадын зарим улсаас монгол хаадын түүхэнд хамаарах онцлог үзмэрүүдийг хуулбарлан авах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, дэлхийн 11 улсаас 30 үзмэрийн "A" болон дижитал хуулбарыг авч, музейд хулээлгэн өгсөн.

Соёлын дипломат харилцааг Соёлын элчээр дамжуулан хэрэгжүүлж байна. Энэхүү ардын дипломатын арга нь урт хугацааны туршид тасралтгүй, тууштай хэрэгжүүлэх зөвлөн хүчний бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ чиглэлээр Соёлын элч нарын үйл ажиллагааг төрийн бодлоготой уялдуулах, олон нийтэд сурталчлах, эрх зүйн орчныг нь сайжруулах, дипломат шугамаар дэмжлэг үзүүлэх, гадаад сурталчилгаа болон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл явцад оролцоог нь нэмэгдүүлэхэд анхаарч, "Соёлын элчийн ажиллах журам"-ыг шинэчлэн батлав.

Өнөөдөр дэлхийн 19 оронд 50 соёлын элч томилон ажиллуулж байна. Соёлын элч нар 2021 онд 30 гаруй, 2022 онд 20 гаруй соёл, урлагийн арга хэмжээнд амжилттай оролцсоны зэрэгцээ бие даан зохион байгуулсан нь Монгол Улсыг гадаадад сурталчлах үйл ажиллагаанд тодорхой хувь нэмэр оруулсан.

Монгол Улс Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа заасны дагуу олон тулгуурт гадаад бодлогын зарчмыг эрхэмлэж, дэлхийн улс орнууд, олон улсын байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж, олон улсын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна. Монгол Улсын тэр засгаас хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээ, түүний хэрэгжилт, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, соёл, боловсрол, урлаг, спортын салбарт болж байгаа чухал үйл явдлуудын тухай бодит мэдээ, мэдээллийг гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлж, сурталчлан таниулахад ард түмэн хоорондын найрамдал, нехерлэлийн бат бэх гүүр болдог сэтгүүлч, сурвалжлагч нар чухал үүрэг гүйцэтгэдэг.

Монгол Улсад өнөөдөр Катар Улсын "Аль Жазийра", БНХАУ-ын "Синьхуа", "Жиньминь Жибао" сонин, "Хятадын төв радио, телевиз" буюу CCTV, Япон Улсын "Асахи Шимбун", "Киодо Цүүшин", "Фүжи" телевиз, ОХУ-ын "Mongolnow.com", Англи Улсын "Ройтерс", ХБНГУ-ын "bne intelliNews" БНФУ-ын "Agence France Presse", АНУ-ын "Ассошиэйтед пресс", БНСУ-ын "KBS" телевиз зэрэг нийт 14 хэвлэл, мэдээллийн агентлагийн 21 сурвалжлагч, зураглаач байнгын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын Монгол Улсад ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэхийг зорин ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас гадаад сурталчилгааны үйл ажиллагааг цогц, нэгдмэл байдлаар зохицуулах зорилгоор "Монгол Улсыг гадаадад сурталчлах арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө"-г батлан хэрэгжүүлж байгаа болно.

-----оОо-----